



ҮНСНИЙ ХИЙН ХААЛТ ДУ 50, 80, 200 ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

20 ~~03~~ оны 08 -р сарын 24 өдөр

Дугаар.. 0008 | 67

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” ТӨХК /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас “Тамир Булаг” ХХК-ийг төлөөлж захирал П.Цэнд-Аюуш /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Үнсний хийн хаалт ДУ 50, 80, 200” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох хавсралтад заасан нэр төрөл, тоо хэмжээ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу захиалагчийн агуулахад нийлүүлнэ.

Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ 60,786,000 / Жаран сая долоон зуун наян зургаан мянга/-н төгрөг бөгөөд үнийн дүнд гааль онцгой албан татвар, захиалагчийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд орсон байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

3.3 Барааг хүлээлгэн өгсөний дараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нэхэмжлэлийн дагуу нийлүүлэгчийн Хаан банкны 5916076699 тоот дансанд шилжүүлнэ.

Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа

- төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Барааг захиалагчийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана. Буцаах зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- 4.4 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилтгэй холбоотой асуудлыг Зуухан цехийн дарга Э.Ариунболд хариуцан ажиллана. Утас-89000800.
- 4.5 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг “Тамир Булаг” ХХК-ийн захирал П.Цэнд-Аюуш хариуцан ажиллана. Утас- 96202101.

Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Бараа нь тээвэрлэлт, хадгалалтын үед гэмтэж цоорохоос хамгаалсан сав, баглаа, боодолтой байна.
- 5.3 Барааг захиалагчид хүлээлгэн өгөх үед энэхүү гэрээгээр тодорхойлсон шинж чанарт нийцэж байвал зохих бөгөөд цаашид технологийн горим, зориулалтын дагуу ашиглах хугацаанд чанараа алдахгүй байх ёстой.
- 5.4 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.5 Нийлүүлэгч нь нийлүүлсэн бараанд өөрийн үйл ажиллагаатай холбоотой гэмтэл согог, дутагдал гарсан тохиолдолд өөрийн зардлаар засаж залруулах, сольж өгөх үүрэгтэй.

Зургаа. Бараа хүлээн авах

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг захиалагчийн агуулахад хүргэх ба захиалагч талаас бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.
- 6.3 Нийлүүлэгч нь барааг захиалагчийн өгсөн техникийн тодорхойлолтын дагуу хүлээлгэн өгнө.
- 6.4 Нийлүүлэгч нь захиалагчид гэрээний хавсралтын дагуу тоо ширхэгээр хүлээлгэн өгнө.
- 6.5 Үйлдвэрийн гарал үүслийн гэрчилгээ.
- 6.6 Баталгаат хугацаа 1 жил байна.

Долоо. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, хорио цээр тогтоох, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй.
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд гэрээний хугацаа дуусахаас өмнө талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллаар зөвшилцөнө.

Найм. Гэрээг цуцлах үндэслэл

- 8.1 Нийлүүлэгч нь барааг энэхүү гэрээний 2.1-т заасан материал нийлүүлэх хугацаанаас хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн

Захиалагч

М. /J/-

дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцална.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 3 хувь үйлдэж, Захиалагч 2 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд 1 удаа сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

The signature is handwritten in blue ink, appearing to read "Эрхүйн Нергээгийн".

Э.МОНХЖАРГАЛ

СЭЗХ-ИЙН ДАРГА
БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

The signature is handwritten in blue ink, appearing to read "Сэзх-ийн Дарга".

Ө.УДВАЛ

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

The signature is handwritten in blue ink, appearing to read "Ажуу, Хангамжийн Хэлтсийн Дарга".

Г.БАТТУЛГА

ЗУУХАН ЦЕХИЙН
ДАРГА

The signature is handwritten in blue ink, appearing to read "Зуухан Цехийн Дарга".

Э.АРИУНБОЛД

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН :

Хангамжийн мэргэжилтэн

The signature is handwritten in blue ink, appearing to read "М.МОЛОМЖАВ".

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ТАМИР БУЛАГ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

The signature is handwritten in blue ink, appearing to read "Тамир Булаг Захирагч".

П.ЦЭНД-АЮУШ

Хаяг: Монгол улс, Улаанбаатар
хот, Баянзурх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

Хаяг: Монгол улс, Хөвсгөл аймаг, Мөрөн сум 09ба.
Утасны дугаар: 99065975, 96202101
РД: 4141067

Захиалагч

The signature is handwritten in blue ink, appearing to read "Захиалагч".

3/4

Нийлүүлэгч